

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.02.15

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт **75.4** хувьтай дүгнэгдсэн байна.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 67 арга хэмжээ тусгагдсан бөгөөд жилийн эцсийн хэрэгжилтийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)						Хугацаа болоогүй
		100	90	70	50	30	0	
67	75.4	36	6	3	8	10	4	-

Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газар нь 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 67 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийт 67 арга хэмжээнээс 100 хувийн хэрэгжилттэй 36, 90 хувийн хэрэгжилттэй 6, 70 хувийн хэрэгжилттэй 3, 50 хувийн 8, 30 хувийн хэрэгжилттэй 10, 0 буюу хэрэгжүүлээгүй 4 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилт дунджаар 75.4 хувьтай байна.

2.2. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Зам, тээврийн сайдын хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг суурь түвшинтэй нь харьцуулан /томъёоны дагуу/ гаргасан бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна.

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)							
		100	90	70	50	46.7	30	13.3	0

8	32.5	2	-	-	-	1	-	1	4
---	------	---	---	---	---	---	---	---	---

2.3. Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт дараах байдалтай байна.

Нийт заалт	Хэрэгжилтийн хувь	Үүнээс (хувиар)						
		100	90	70	50	30	0	Хугацаа болоогүй
2	95.0	1	1	-	-	-	-	-

2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Эрхзүйн актын нэр	Нийт заалт	Хэрэгжилт (хувиар)	Үүнээс (хувиар)				
			100	70	30	0	Хугацаа болоогүй
Монгол Улсын хууль	1	-	-	-	-	-	1
УИХ-ын Байнгын хорооны тогтоол	1	70.0	-	1	-	-	-
УИХ-ын тогтоол	9	51.1	3	1	3	2	-
Засгийн газрын тогтоол	18	53.7	4	4	6	2	2
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	33	65.6	17	5	6	5	-
Засгийн газрын албан даалгавар	8	38.5	1	-	7	-	-
Дүн	70	58.7	25	11	22	9	3

2.5. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт дараах байдалтай байна.

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)				
		100	70	30	0	Хугацаа болоогүй
66	86.2	45	12	6	1	2

Хэрэгжүүлэх заалт: 3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газар (Х.Итгэлт), Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (А.Мөнхбат)-т даалгасугай.

Хэрэгжилт: Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

I. Шийдвэрийн нэр, огноо, дугаар: Ажлын хэсэг байгуулах тухай 2024.03.14-ний өдрийн №А/136 дугаар тушаал

Хэрэгжүүлэх заалт: 3.Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын барилгын ажлын нээлтийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж тайлагнах

Хэрэгжилт: Зам, тээврийн сайдаар ахлуулсан бүрэлдэхүүн БНХАУ-д 2024 оны 09 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд айлчилж Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх талаар хэлэлцээр хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

2.6. ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт дараах байдалтай байна.

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)				
		100	70	30	0	Хугацаа болоогүй
63	98.1	59	4	-	-	-

Гурав. Дүгнэлт

I. Төлөвлөлтийн байдал

1. ТЗДТБЗГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний зорилтот түвшнийг улирал бүрээр төлөвлөж хэвшсэн байна. Түүнчлэн тус газар 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө 6 зорилтын хүрээнд 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр, яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

II. Хэрэгжилтийн байдал:

1. Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын үйл ажиллагаанд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тус газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 75.4 хувьтай дүгнэгджээ.

2. Тайлант хугацаанд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн нийт **67** арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 36, гол үр дүн нь гарч эхэлж байгаа буюу 90 хувийн хэрэгжилттэй 6, гүйцэтгэл нь тодорхой тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувийн хэрэгжилттэй 3, эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувийн хэрэгжилттэй 8, хэрэгжилт хангалтгүй 30 хувьтай 10, хэрэгжээгүй тасарсан 4 арга хэмжээ байна. Энэхүү үнэлгээ нь өмнөх буюу гуравдугаар улиралтай харьцуулахад 0.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

3. Тус газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээ болох төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд цахим гэрчилгээ олгох, хяналт тавих гэсэн ажилтай холбоотой судалгаа, мэдээллийг бэлтгэн Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн ч тодорхой ахиц гараагүй хэвээр байна.

4. Мөн КОЙКА-ийн төсөлтэй уялдуулан хөгжүүлнэ гэсэн шалтгаанаар 2.17. Төмөр замын тээвэрт цахим гэрчилгээ /RFID/-г нэвтрүүлж, хяналтыг хэрэгжүүлэх, судлах ажлыг зогсоосон тул жилийн турш хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн.

5. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2024.01.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээс үүдэн төмөр замын салбарт хэрэгжиж буй төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах, зохион байгуулалт хийх эрх зүйн боломжгүй болсон тул хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй хэрэгжүүлэн ажиллахад хүрчээ.

6. ТЗДТБЗГ-ын 2022, 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн зөвлөмжөөс дараах зөвлөмжүүд бүрэн хэрэгжээгүй хэвээр байна. Үүнд:

- Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбоотойгоор төмөр замын агентлагийн бүтэц, орон тоог хууль тогтоомжид нийцүүлэн оновчтой батлуулж, тодорхой ажлыг хэрэгжүүлж эхлэх;
- Газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжүүлээгүй, үр дүн муутай, ялангуяа он, он дамжин хэрэгжилт удааширч байгаа арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарах. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжин хотын Дуньзян боомтод олон улсын тээвэр, логистикийн төв төслийг эхлүүлэх,
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүйгээр хэрэгжүүлэх боломжтой стандартыг боловсруулан батлуулах ажлыг эрчимжүүлэх;
- Бүрэн хэрэгжсэн ч тогтмол зохион байгуулагддаг арга хэмжээний биелэлтийг улирал бүр шинэчилж, монгол хэлний зөв бичгийн дүрмийн алдаагүй, товч, тодорхой, хоёр мянган тэмдэгтэд багтаан, тоо баримт, огноог тодорхой дурдан тайлагнаж хэвших;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулж батлуулах;

2. Тус газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс хэрэгжээгүй арга хэмжээнүүдийг бодлогын баримт бичиг болон яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээний зорилтот түвшинтэй уялдуулан 2025 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;

3. Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан үр дүн муутай, ялангуяа он дамжин хэрэгжилт удааширч байгаа арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарах. Үүнд:

- Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.7 км төмөр замын төслийн хүрээнд Бичигт-Зүүнхатавч боомтын хил холболтын төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх,
- Эрээнцав-Чойбалсан чиглэлийн төмөр замын засварыг эхлүүлэх,
- Улаанбаатар-Хархорин чиглэлийн хурдны төмөр замын ТЭЗҮ боловсруулах,
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжин хотын Дуньзян боомтод олон улсын тээвэр, логистикийн төв төслийг эхлүүлэх,
- Төмөр замын тээврийн тариф тогтоох аргачлал боловсруулах зэрэг арга хэмжээнүүд юм.

4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүйгээр хэрэгжүүлэх боломжтой хуулийн төсөл боловсруулах, стандарт боловсруулан батлуулах ажлыг төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжүүлж ажиллах;

5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд бодитой ахиц гаргаж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд хэрэгжих төмөр замын төслүүдийг бүрэн хэрэгжүүлэх;

6. Яамны бусад газартай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө тухайн ажлыг хариуцан хэрэгжүүлэх чиг үүрэг, хүрэх түвшин, оролцоо, хариуцлагыг тодорхой тусгаж, хэрэгжилтийг хангах;

7. Бүрэн хэрэгжсэн ч тогтмол зохион байгуулагддаг арга хэмжээний биелэлтийг улирал бүр шинэчилж, монгол хэлний зөв бичгийн дүрмийн алдаагүй, товч, тодорхой, хоёр мянган тэмдэгтэд багтаан, тоо баримт, огноог тодорхой дурдан тайлагнаж хэвших;

8. Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, төлөвлөлтийг зөв тодорхойлж, ажлаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР